



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2021 ОНЫ НЭГДҮГЭЭР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	5
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	5
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	7
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	8
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	8
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	9
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	9
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	10
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	11
3.4 Зээлийн чанарын талаар.....	12
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	14
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	14
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	15
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	15
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	16
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	16
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	17
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	17
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	17
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	18
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	18
5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	19
5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	19
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	20
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	20
6.2 Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	21
6.3 Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	22
ДОЛОО.ДҮГНЭЛТ	22

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2021 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021.04.29


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 249 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 ХЗХ буюу 2.0 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 40.6 хувь буюу 101 ХЗХ орон нутагт, 59.4 хувь буюу 148 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 39 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 2021 оны 1 дүгээр улиралд 5 ХЗХ-ны сонгуульт гишүүд, 1 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2017	2018	2019	2020	2021.I
ХЗХ-дын тоо	290	279	261	249	249
Шинээр олгосон	17 /1/	18	17	14	-
Хүчингүй болгосон	8	29	35	26	-
Түдгэлзүүлсэн	21	19	10	23	-
Сэргээсэн	4	7	1	6	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	54	100	52	49	39

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа




1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 249 ХЗХ 61 салбар, 829 ажилтан, 75,002 гишүүн /74,819 иргэн, 183 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт 148 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 ХЗХ буюу 7.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 101 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 ХЗХ буюу 7.4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Орхон, Увс, Говь-Алтай, Ховд аймгуудад ХЗХ-д ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 7 ХЗХ 61 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт ороогүй байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 3 ХЗХ-ны 54 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд “Гялс төгрөг” ХЗХ-ны 52 салбар Төв аймаг, Баян-Өлгий аймгаас бусад 19 аймагт тархалттай байна.

График 2: “Гялс төгрөг” ХЗХ-ны салбарын тархалт



1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 301 гишүүн буюу 0.4 хувиар нэмэгдэж 75,002-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.2 хувь буюу 183 хуулийн этгээд, 52.6 хувь буюу 39,480 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 60.0 хувь буюу 45,037 гишүүн Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг бол 40.0 хувь буюу 29,965 гишүүн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.


График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



2018-2021 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо тогтмол өссөөр байна.

Нийт 249 ХЗХ-ны 47.0 хувь буюу 117 ХЗХ 20-100 гишүүнтэй, 41.8 хувь буюу 104 ХЗХ 101-500 гишүүнтэй, 7.6 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 3.6 хувь буюу 9 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



- 20-100 гишүүнтэй
- 101-500 гишүүнтэй
- 501-1,000 гишүүнтэй
- 1,001-ээс дээш гишүүнтэй

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 9 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 47.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	117	6,498	8.7%
101-500 гишүүнтэй	104	20,659	27.5%
501-1,000 гишүүнтэй	19	12,468	16.6%
1,001-ээс дээш гишүүнтэй	9	35,377	47.2%
Нийт	249	75,002	100.0%

Хүснэгт 4:ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт зээлдэгч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	249	100.0%	148	59.4%	101	40.6%
Нийт зээлийн үлдэгдэл	192,066,061.51	100.0%	159,182,749.49	82.9%	32,883,312.01	17.1%
Нийт зээлдэгчийн тоо	38,353	100.0%	22,064	57.5%	16,289	42.5%
Иргэн	38,277	99.8%	22,008	99.7%	16,269	99.9%
Хуулийн этгээд	76	0.2%	56	0.3%	20	0.1%
Зээлдэгчдийн насжилт	38,277	100.0%	22,008	57.5%	16,269	42.5%
18-35 насны	16,220	42.4%	12,059	54.8%	4,161	25.6%
36-45 насны	9,486	24.8%	4,360	19.8%	5,126	31.5%
46-55 насны	8,645	22.6%	4,161	18.9%	4,484	27.6%
55-аас дээш	3,926	10.2%	1,428	6.5%	2,498	15.3%
Зээлдэгчдийн боловсрол	38,277	100.0%	22,008	57.5%	16,269	42.5%
Дээд	13,832	36.1%	8,911	40.5%	4,921	30.2%
Тусгай дунд	7,160	18.7%	4,257	19.3%	2,903	17.8%
Бүрэн дунд	12,277	32.1%	6,717	30.5%	5,560	34.2%
Дунд	4,195	11.0%	2,037	9.3%	2,158	13.3%
Бага	813	2.1%	86	0.4%	727	4.5%

Тайлант улиралд ХЗХ-д 38,353 зээлдэгчийн 192,066,061.51 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 57.5 хувь буюу 22,064 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 82.9 хувь буюу 159,182,749.49 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 42.5 хувь буюу 16,269 зээлдэгч орон нутгийн ХЗХ-

дын гишүүд ба нийт зээлийн 17.1 хувь буюу 32,883,312.01 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.8 хувь буюу 38,277 нь хувь хүн, 0.2 хувь буюу 76 нь хуулийн этгээд байна.

Хүснэгт 5:ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	249	100.0%	148	59.4%	101	40.6%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	201,351,467.05	100.0%	172,586,560.42	85.7%	28,764,906.63	14.3%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	40,166	100.0%	22,131	55.1%	18,035	44.9%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	2,889,838.86	1.4%	2,362,572.86	1.4%	527,266.00	1.8%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,622	11.5%	3,651	16.5%	971	5.4%
Иргэн	4,599	11.4%	3,630	16.4%	969	5.4%
Хуулийн этгээд	23	0.1%	21	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	198,461,628.19	98.6%	170,223,987.56	98.6%	28,237,640.64	98.2%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	35,544	88.5%	18,480	83.5%	17,064	94.6%
Иргэн	35,502	88.4%	18,467	83.4%	17,035	94.5%
Хуулийн этгээд	42	0.1%	13	0.1%	29	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	40,101	100.0%	22,097	55.1%	18,004	44.9%
18-35 насны	11,174	27.9%	6,549	29.6%	4,625	25.7%
36-45 насны	13,170	32.8%	8,399	38.0%	4,771	26.5%
46-55 насны	9,930	24.8%	4,397	19.9%	5,533	30.7%
55-аас дээш	5,827	14.5%	2,752	12.5%	3,075	17.1%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	40,101	100.0%	22,097	55.1%	18,004	44.9%

Дээд	21,117	52.7%	14,328	64.8%	6,789	37.7%
Тусгай дунд	5,484	13.7%	3,160	14.3%	2,324	12.9%
Бүрэн дунд	8,691	21.7%	3,732	16.9%	4,959	27.6%
Дунд	3,226	8.0%	504	2.3%	2,722	15.1%
Бага	1,583	3.9%	373	1.7%	1,210	6.7%

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 40,166 хадгаламж эзэмшигчийн 201,351,467.05 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 55.1 хувь буюу 22,131 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 85.7 хувь буюу 172,586,560.42 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 44.9 хувь буюу 18,035

хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 14.3 хувь буюу 28,764,906.63 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 11.5 хувийг хугацаагүй хадгаламжтай, 88.5 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 40,101 нь хувь хүн, 0.2 хувь буюу 65 нь хуулийн этгээд байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 278,934,885.48 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувь буюу 49,400,139.63 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.7 хувьтай тэнцэж байна.

нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 26.6 хувь буюу 42,335,642.52 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 2.0 хувь буюу 280,380.47 мянган төгрөг, нийт зарлага 7.7 хувь буюу 914,833.59 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 28.9 хувь буюу 634,453.12 мянган төгрөгөөр буурч 1,560,252.01 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 11.1 хувь буюу 19,125,826.69 мянган төгрөг,

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны I улирал	2021 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	229,534,745.85	278,934,885.48		
Банкны зах зээлд эзлэх хувь	0.7%	0.7%	49,400,139.63	21.5%
Нийт зээл	172,940,234.82	192,066,061.51		
Банкны зах зээлд эзлэх хувь	1.0%	1.1%	19,125,826.69	11.1%
Нийт чанаргүй зээл	7,410,269.97	6,986,906.18		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.3%	3.6%	-0.6%	-15.1%
Банкны зах зээлд эзлэх хувь	0.5%	0.4%	-0.1%	-17.3%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	159,015,824.53	201,351,467.05		
Банкны зах зээлд эзлэх хувь	1.2%	1.1%	42,335,642.52	26.6%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18,414,215.28	21,324,485.71		
Нийт хоршоологчдын өмч	24,646,588.83	29,597,084.38		
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	10,680,697.86	7,493,925.79		
Нийт орлого	14,033,161.76	14,313,542.23	280,380.47	2.0%
Нийт зарлага	11,838,456.63	12,753,290.22	914,833.59	7.7%
Цэвэр орлого, алдагдал	2,194,705.13	1,560,252.01	-634,453.12	-28.9%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 148 ХЗХ-ны нийт хөрөнгө 236,260,011.36 мянган төгрөг нь зах зээлийн 84.7 хувь, нийт зээл 159,182,749.49 мянган төгрөг нь зах зээлийн 82.9 хувь, нийт хадгаламж 172,586,560.42 мянган төгрөг нь зах зээлийн 85.7 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.1 хувь буюу 413,874.48 мянган төгрөгөөр буурч 6,414,072.32 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 4.0 хувийг бүрдүүлж байна. Банк, ББСБ, төсөл

хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 30.9 хувь буюу 3,262,626.20 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 2.8 хувь буюу 321,734.53 мянган төгрөгөөр буурч, нийт зарлага 3.5 хувь буюу 353,925.30 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр цэвэр орлого 40.0 хувь буюу 675,659.83 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын 79 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны I	2021 оны I	Өөрчлөлт	
	улирал	улирал	дүн	хувь
Нийт хөрөнгө	198,024,810.33	236,260,011.36	38,235,201.02	19.3%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	86.3%	84.7%	-1.6%	-1.8%
Нийт зээл	147,504,485.01	159,182,749.49	11,678,264.48	7.9%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	85.3%	82.9%	-2.4%	-2.8%
Нийт чанаргүй зээл	6,827,946.80	6,414,072.32	-413,874.48	-6.1%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	92.1%	91.8%	-0.3%	-0.4%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.6%	4.0%	-0.6%	-13.0%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	139,574,195.91	172,586,560.42	33,012,364.51	23.7%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	87.8%	85.7%	-2.1%	-2.3%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	13,032,019.98	15,669,377.12	2,637,357.14	20.2%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	70.8%	73.5%	2.7%	3.8%
Нийт хоршоологчдын өмч	19,960,768.54	23,965,944.33	4,005,175.79	20.1%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	81.0%	81.0%	0.0%	0.0%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	10,549,541.09	7,286,914.90	-3,262,626.20	-30.9%
Нийт орлого	11,698,152.36	11,376,417.84	-321,734.53	-2.8%
Нийт зарлага	10,011,090.39	10,365,015.69	353,925.30	3.5%
Цэвэр орлого, алдагдал	1,687,061.97	1,011,402.15	-675,659.83	-40.0%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 101 ХЗХ-ны нийт хөрөнгө 42,674,874.12 мянган төгрөг нь зах зээлийн 15.3 хувь, нийт зээлийн үлдэгдэл 32,883,312.01 мянган төгрөг нь зах зээлийн 17.1 хувь, нийт хадгаламж 28,764,906.63 мянган төгрөг нь зах зээлийн 14.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 25.8 хувь буюу 602,115.01 мянган төгрөг, нийт зарлага 30.7 хувь буюу 560,908.29 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 8.1 хувь буюу 41,206.71 мянган төгрөгөөр

нэмэгдэж 548,849.86 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн 31 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны I	2021 оны I	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	хувь
Нийт хөрөнгө	31,509,935.52	42,674,874.12	11,164,938.61	35.4%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	13.7%	15.3%	1.6%	11.4%
Нийт зээл	25,435,749.81	32,883,312.01	7,447,562.20	29.3%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	14.7%	17.1%	2.4%	16.4%
Нийт чанаргүй зээл	582,323.17	572,833.87	-9,489.30	-1.6%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	7.9%	8.2%	0.3%	4.3%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.4%	0.4%	0.0%	-8.8%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	19,441,628.62	28,764,906.63	9,323,278.02	48.0%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	12.2%	14.3%	2.1%	16.8%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	5,382,195.30	5,655,108.59	272,913.29	5.1%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	29.2%	26.5%	-2.7%	-9.3%
Нийт хоршоологчдын өмч	4,685,820.29	5,631,140.06	945,319.77	20.2%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	19.0%	19.0%	0.0%	0.1%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	131,156.76	207,010.89	75,854.13	57.8%
Нийт орлого	2,335,009.40	2,937,124.39	602,115.01	25.8%
Нийт зарлага	1,827,366.24	2,388,274.53	560,908.29	30.7%
Цэвэр орлого, алдагдал	507,643.15	548,849.86	41,206.71	8.1%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2020 оны I улирал		2021 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	225,274,697.00	98.1%	271,551,440.44	97.4%	46,276,743.44	20.5%
Мөнгөн хөрөнгө	47,228,268.10	20.6%	73,619,936.59	26.4%	26,391,668.49	55.9%
Бэлэн мөнгө	2,630,809.20	1.1%	4,530,196.38	1.6%	1,899,387.18	72.2%
Банкинд байршуулсан харилцах	36,906,556.90	16.1%	20,058,679.83	7.2%	-16,847,877.07	-45.7%
Банкинд байршуулсан хадгаламж	7,690,902.00	3.4%	49,031,060.39	17.6%	41,340,158.39	537.5%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	100,000.00	0.0%	150,000.00	0.1%	50,000.00	50.0%
Арилжааны үнэт цаас	100,000.00	0.0%	150,000.00	0.1%	50,000.00	50.0%
Зээл /цэврээр/	167,970,174.50	73.2%	186,969,058.63	67.0%	18,998,884.13	11.3%
Нийт зээл	172,940,234.80	75.3%	192,066,061.51	68.9%	19,125,826.71	11.1%
Хэвийн зээл	159,524,180.40	69.5%	179,521,742.67	64.4%	19,997,562.27	12.5%
Хугацаа хэтэрсэн зээл	6,005,784.50	2.6%	5,557,412.65	2.0%	-448,371.85	-7.5%
Чанаргүй зээл	7,410,270.00	3.2%	6,986,906.18	2.5%	-423,363.82	-5.7%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,970,060.30	2.2%	5,097,002.88	1.8%	126,942.58	2.6%
Авлага	8,185,117.10	3.6%	9,304,641.47	3.3%	1,119,524.37	13.7%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	1,546,844.30	0.7%	778,749.49	0.3%	-768,094.81	-49.7%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	6,638,272.80	2.9%	8,525,891.98	3.1%	1,887,619.18	28.4%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,048,850.00	0.5%	720,639.37	0.3%	-328,210.63	-31.3%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/	742,287.30	0.3%	787,164.39	0.3%	44,877.09	6.0%
Өмчлөх бусад хөрөнгө	792,698.00	0.3%	793,242.74	0.3%	544.74	0.1%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	50,410.70	0.0%	6,078.35	0.0%	-44,332.35	-87.9%
Эргэлтийн бус хөрөнгө	4,260,048.80	1.9%	7,383,445.04	2.6%	3,123,396.24	73.3%
Үндсэн хөрөнгө /цэвр/	3,994,784.40	1.7%	4,303,600.88	1.5%	308,816.48	7.7%
Үндсэн хөрөнгө	5,359,891.10	2.3%	6,083,164.46	2.2%	723,273.36	13.5%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,365,106.70	0.6%	1,779,563.58	0.6%	414,456.88	30.4%
Биет бус хөрөнгө	249,644.40	0.1%	3,064,356.36	1.1%	2,814,711.96	1127.5%
Биет бус хөрөнгө	303,644.50	0.1%	3,143,098.46	1.1%	2,839,453.96	935.1%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	54,000.10	0.0%	78,742.09	0.0%	24,741.99	45.8%

Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,620.00	0.0%	15,487.79	0.0%	-132.21	-0.8%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,620.00	0.0%	15,487.79	0.0%	-132.21	-0.8%
Хөрөнгийн дүн	229,534,745.90	100.0%	278,934,885.48	100.0%	49,400,139.58	21.5%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.1 хувь буюу 19,125,826.71 мянган төгрөгөөр өсөж 192,066,061.51 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,097,002.88 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 186,969,058.63 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувь буюу 448,371.85 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.


ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2018-2021 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 185,850,638.30 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 66.6 хувийг, гишүүдийн тоо 23,631 байгаа нь нийт гишүүдийн 31.5 хувийг тус тус эзэлж байна.


Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө			
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	185,850,638.30	66.6%	23,631	31.5%
2	1,000,000.0 - 10,000,000.0	17	53,747,729.65	19.3%	18,944	25.3%
3	500,000.0-1,000,000.0	20	14,764,664.85	5.3%	7,634	10.2%
4	100,000.0-500,000.0	81	17,305,964.62	6.2%	14,721	19.6%
5	50,000.0-100,000.0	80	6,026,663.81	2.2%	7,486	10.0%
6	10,000.0-50,000.0	39	1,195,765.16	0.4%	2,379	3.1%
7	10,000.0 хүртэл	8	43,459.09	0.0%	207	0.3%
Нийт дүн		249	278,934,885.48	100.0%	75,002	100.0%



2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 278,934,885.48 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувь буюу 49,400,139.58 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 97.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 2.6 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 26.4 хувийг, цэвэр зээл 67.0 хувийг тус тус эзэлж байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээлийн нийт зээлийн үлдэгдэл 192,066,061.5 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 68.9 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 186,969,058.63 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 67.0 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.4 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 19 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 83.5 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 7 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	19	160,378,431.08	83.5%
	500,000.0-	14	9,074,122.97	4.7%
2	1,000,000.0			
3	100,000.0-500,000.0	68	15,515,658.40	8.1%
4	50,000.0-100,000.0	74	5,217,004.98	2.7%
5	10,000.0-50,000.0	57	1,819,178.12	1.0%
6	10,000.0 хүртэл	10	61,665.96	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	7	-	-
Нийт дүн		249	192,066,061.51	100%

Хүснэгт 12: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5,375,861.13	2,925,552.27	2,155,894.95	6,145,518.46	3.2%
2	Уул уурхай, олборлолт	1,843,368.42	360,863.00	248,998.00	1,955,233.42	0.9%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,992,113.93	513,479.57	638,469.60	1,867,123.90	1.0%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	345,314.46	151,674.40	182,819.78	314,169.07	0.2%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	46,374.71	100,000.00	544.43	145,830.28	0.1%
6	Барилга	4,355,900.34	1,940,045.39	2,004,888.64	4,291,057.10	2.2%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	16,127,604.15	7,137,972.08	6,375,202.14	16,890,374.09	8.8%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	1,193,972.84	257,723.55	246,651.66	1,205,044.73	0.6%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	310,612.40	498,575.46	244,947.58	564,240.28	0.3%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3,899,960.87	894,471.82	971,285.36	3,823,147.33	2.0%
11	Мэдээлэл холбоо	105,224.44	1,093.13	170.98	106,146.59	0.1%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5,305,122.52	10,410,743.40	5,573,835.89	10,142,030.03	5.3%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2,354,269.18	627,150.40	743,943.25	2,237,476.33	1.2%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	63,457.55	2,600.00	105.29	65,952.26	0.0%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	323,680.36	9,700.00	35,500.90	297,879.47	0.2%
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,880.00	250	0	2,130.00	0.0%
17	Боловсрол	1,161,822.48	466,751.94	436,989.13	1,191,585.30	0.6%
18	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	981,791.10	345,638.63	334,849.54	992,580.20	0.5%
19	Бусад	121,784,680.19	99,541,106.43	81,497,243.95	139,828,542.67	72.8%
	Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл	14,447,894.84	10,551,520.58	9,708,856.16	15,290,559.26	8.0%
НИЙТ		167,573,011.08	126,185,391.48	101,692,341.05	192,066,061.51	100.00%

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 126,185,391.48 мянган төгрөгийн зээл олгож, 101,692,341.05 мянган

төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 192,066,061.51 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг

зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 72.8 хувь буюу 139,828,542.67 мянган төгрөгийг бусад, 8.8 хувь буюу 16,890,374.09 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 3.2 хувь буюу 6,145,518.46 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 5.8 хувь буюу 10,142,030.03

мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 2.2 хувь буюу 4,291,057.10 мянган төгрөгийн барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 8.0 хувь буюу 15,290,559.26 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

3.4 Зээлийн чанарын талаар


Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	38,353	100.0%	192,066,061.51	100.0%
Хэвийн	35,476	92.5%	179,521,742.67	93.5%
Хугацаа хэтэрсэн	1,137	3.0%	5,557,412.65	2.9%
Чанаргүй	1,740	4.5%	6,986,906.18	3.6%
<i>Хэвийн бус</i>	880	2.3%	1,942,781.05	27.8%
<i>Эргэлзээтэй</i>	350	0.9%	1,523,568.81	21.8%
<i>Муу</i>	510	1.3%	3,520,556.33	50.4%

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.5 хувь буюу 179,521,742.67 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.9 хувь буюу 5,557,412.65 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.6 хувь буюу 6,986,906.18 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,544,318.84 мянган төгрөгийн үлдэгдэлд 40.6 хувь буюу 5,097,002.88 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.5 хувийг хэвийн, 3.0 хувийг хугацаа хэтэрсэн, 4.5 хувийг чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,740 зээлдэгчийн 6,986,906.18 мянган төгрөгийн үлдэгдлийн 27.8 хувийг хэвийн бус, 21.8 хувийг эргэлзээтэй, 50.4 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 8: Зээлийн чанар



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 пунктээр өсөж 93.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.6 пунктээр буурч 2.9 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.7 пунктээр буурч 3.6 хувьд хүрсэн байна.


Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар/мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	159,182,749.49	100.0%	82.9%	32,883,312.01	100.0%	17.1%
Хэвийн	148,024,437.62	93.0%	82.5%	31,497,305.05	95.8%	17.5%
Хугацаа хэтэрсэн	4,744,239.55	3.0%	85.4%	813,173.10	2.5%	14.6%
Чанаргүй	6,414,072.32	4.0%	91.8%	572,833.87	1.7%	8.2%
<i>Хэвийн бус</i>	<i>1,555,973.99</i>	<i>24.3%</i>	<i>80.1%</i>	<i>386,807.06</i>	<i>67.5%</i>	<i>19.9%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>1,422,313.82</i>	<i>22.2%</i>	<i>93.4%</i>	<i>101,254.98</i>	<i>17.7%</i>	<i>6.6%</i>
<i>Муу</i>	<i>3,435,784.50</i>	<i>53.6%</i>	<i>97.6%</i>	<i>84,771.82</i>	<i>14.8%</i>	<i>2.4%</i>

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 82.9 хувь буюу 159,182,749.49 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 17.1 хувь буюу 32,883,312.01 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 93.0 хувь буюу 148,024,437.62 мянган төгрөгийг хэвийн, 3.0 хувь буюу 4,744,239.55 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувь буюу 6,414,072.32 мянган төгрөгийн чанаргүй

зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 53.6 хувь буюу 3,435,784.50 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 97.6 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 95.8 хувь буюу 31,497,305.0 мянган төгрөгийг хэвийн, 2.5 хувь буюу 813,173.10 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 1.7 хувь буюу 572,833.87 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 9: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар

Хүснэгт 15: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

ЭХ ҮҮСВЭР	2020 I улирал		2021 I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Өр төлбөр	186,313,141.00	81.2%	227,845,478.68	81.7%	41,532,337.68	22.3%
Хадгаламж	159,015,824.50	69.3%	201,351,467.05	72.2%	42,335,642.55	26.6%
Хугацаагүй	3,914,870.50	1.7%	2,889,838.86	1.0%	-1,025,031.64	-26.2%
Хугацаатай	155,100,954.00	67.6%	198,461,628.19	71.1%	43,360,674.19	28.0%
Богино хугацаат зээл	3,296,601.60	1.4%	2,492,628.82	0.9%	-803,972.78	-24.4%
Бусад богино хугацаат өр төлбөр	16,524,405.30	7.2%	18,969,504.05	6.8%	2,445,098.75	14.8%
Урт хугацаат өр төлбөр	7,476,309.50	3.3%	5,031,878.76	1.8%	-2,444,430.74	-32.7%
Өөрийн хөрөнгө	43,221,604.90	18.8%	51,089,406.80	18.3%	7,867,801.90	18.2%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18,414,215.30	8.0%	21,324,485.71	7.6%	2,910,270.41	15.8%
Гишүүний оруулсан хувь хөрөнгө	18,164,335.30	7.9%	21,145,357.07	7.6%	2,981,021.77	16.4%
Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	249,880.00	0.1%	179,128.64	0.1%	-70,751.36	-28.3%
Дахин үнэлгээний нэмэгдэл	160,800.80	0.1%	167,836.71	0.1%	7,035.91	4.4%
Хоршоологчдын өмч	24,646,588.80	10.7%	29,597,084.38	10.6%	4,950,495.58	20.1%
Нөөцийн сан	5,118,403.30	2.2%	10,277,322.51	3.7%	5,158,919.21	100.8%
Хандив, тусламж	525,590.00	0.2%	539,408.44	0.2%	13,818.44	2.6%
Хадгаламж, хамгаалалтын сан	1,674,810.30	0.7%	2,145,439.01	0.8%	470,628.71	28.1%
Нийгмийн хөгжлийн сан	1,151,033.90	0.5%	918,993.98	0.3%	-232,039.92	-20.2%
Тогтворжилтын сан	1,678,101.40	0.7%	2,122,823.03	0.8%	444,721.63	26.5%
Бусад сангууд	1,447,113.60	0.6%	1,478,229.37	0.5%	31,115.77	2.2%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	13,051,536.30	5.7%	12,114,868.04	4.3%	-936,668.26	-7.2%
Тайлангийн үеийн цэвэр орлого	2,194,705.10	1.0%	1,560,252.01	0.6%	-634,453.09	-28.9%
Өмнөх үеийн цэвэр орлого	10,856,831.10	4.7%	10,554,616.03	3.8%	-302,215.07	-2.8%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	229,534,745.90	100.0%	278,934,885.48	100.0%	49,400,139.58	21.5%

Зах зээлийн нийт өр төлбөр 227,845,478.68 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.3 хувь буюу 41,532,337.68 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 51,089,406.80 мянган төгрөг нь 18.3 хувь буюу 7,867,801.90 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн бүтцийн 81.7 хувийг өр төлбөр, 18.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

График 10: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



